



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, үндэсний хөтөлбөр"-ийн 2-р зорилтын хүрээнд Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн ажилтныг үзлэг шинжилгээ, эмчилгээнд хамруулах тухай" 02 тоот албан даалгавар, "Аян зохион байгуулах тухай" 1а/1377 албан тоот, А/108 дугаар тушаалын хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор ТУШААХ нь:

1. "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аяныг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, идэвхтэй хамтран ажиллахыг Үндэсний төвийн алба, тасгийн дарга, эрхлэгч, Орон нутгийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

3. Аяныг Үндэсний төв болон Орон нутгийн салбар төвүүдийн хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах, үр дүнг 2017 оны 12 сарын 10-ны дотор багтаан тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч /Э.Тунгалаг/-д үүрэг болгосугай.

4. "Эрүүл мэнд-Ээлтэй орчин" аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг төсөвтэй багтаан холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан /З.Ууганцэцэг/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа төлөвлөлт, статистик, хүний нөөцийн албаны дарга /Б.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

0000067

Төвийн захирлын ..... оны ..... дүгээр  
сарын ..... -ны өдрийн ..... дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Э.Тунгалаг –ЧХУДАА-ны дарга

Гишүүдэд:

Д.Ганболд МТА-ны дарга

З.Ууганцэцэг –СЭЗХҮА-ны дарга

О.Баасанчулуун-Нийслэлийн ЗӨСТ-ийн дарга

Д.Алтанчимэг- Өмнөговь аймгийн ЗӨСТ-ийн дарга


Б.Уртнасан-Хөвсгөл аймгийн ЗӨСТ-ийн дарга

Б.Эрдэнэчимэг-Архангай аймгийн ЗӨСТ

С.Батсайхан-Говь-Алтай аймгийн ЗӨСТ

Г.Дашдаваа-Завхан аймгийн ЗӨСТ

Төвийн захирлын 2017 оны 04 дүгээр сарын 20 ны өдрийн 04 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## "ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН" БҮРДҮҮЛЭХ АЯНЫ УДИРДАМЖ

### Үндэслэл:

Эрүүл мэндийн яамнаас 2017 оныг "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласан, мөн "Элэг бүтэн монгол хүн" хөтөлбөр баталсантай холбогдуулан, "Эрүүл мэндийн ажилтныг үзлэг шинжилгээ, эмчилгээнд хамруулах тухай" Эрүүл мэндийн сайдын 02 тоот албан даалгавар, "Аян зохион байгуулах тухай" 1а/1377 албан тоот, А/108 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд "ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН" аяныг зарлаж байна.

### Зорилго:

Хамт олны болон хувь хүний эрүүл зан үйлийг төлөвшүүлэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, эрүүл аюулгүй ажлын байр бий болгох

### Зорилт:

1. Ажилчдыг вирусын халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд үе шаттай хамруулах
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн эрүүл ажлын байр бий болгох
3. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах
4. Ая тухтай, ажлын ЭКО орчинг бүрдүүлэх

**Хамрах хүрээ:** ЗӨСҮТ, харъяа орон нутгийн ЗӨСТ-үүдийн эрүүл мэндийн ажилтнууд

**Хугацаа:** 2017 оны 04 сарын 15-наас 12 сарын 05 хүртэл

### Үйл ажиллагаа:

1. Байгууллага бүр аян зохион байгуулах талаар ажилчдад танилцуулах, үйл ажиллагааг төлөвлөх
2. Аюулгүй ажлын байр, ая тухтай орчин бүрдүүлэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулан, идэвхтэй хамтран ажиллах
3. Үйл ажиллагааг сурталчилах ажлыг орон нутгийн мэдээллийн сувгуудыг ашиглан мэдээлэх
4. Мэдээ, тайланг хугацаанд нь ажлын хэсэгт ирүүлэх

**Шалгаруулалт:** Шалгаруулалтыг 2017 оны 11-р сарын 05 нд ЗӨСҮТ-ийн байранд орон нутгийн төвүүд болон Үндэсний төвийн төлөөлөл оролцсон 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хамтран зохион байгуулна.

### Аяныг дүгнэх журам:

1. Аяныг дүгнэх ажлын хэсэг шалгаруулалтад ил тод нээлттэй зарчмыг баримтлана.
2. Аяны болзлын явцын хэрэгжилтийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн мэдээллийг үндэслэл болгоно.
3. Аян зохион байгуулсан үйл ажиллагааны талаар фото зураг болон видео бичлэгээр баримтжуулсан тайланд шалгуурын дагуу үнэлгээ өгнө.
4. ЗӨСТ-үүдээс 3 байгууллага, мөн байгууллага бүрээс санал болгосон ажилчдаас 3 ажилтныг шалгаруулна.
5. Байгууллагуудаас санал болгосон ажилтан нь тухайн аяны хугацаанд бусдыгаа манлайлан идэвхтэй оролцсон байна.
6. Ажлын хэсэг нь байгууллагуудаас ирүүлсэн материалыг ажлын 1-2 хоногт багтаан дүгнэж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт шийдвэр гаргуулна.

### Шагнал урамшуулал:

1. Аяны хүрээнд хийсэн ажлаараа манлайлан оролцож, тэргүүлсэн 3 байгууллагыг "Аюулгүй ажиллагааг хангасан шилдэг байгууллага", "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага", "Шилдэг ЭКО орчин бүрдүүлсэн байгууллага" зэрэг номинацуудад шалгаруулж, урамшуулна.
2. Бусдыгаа манлайлагч 3 ажилтныг шалгаруулж, Сингапур улсад сургалтад хамруулна /Тухайн байгууллагаас санал болгосон ажилтан байна/.

### Шалгаруулах үзүүлэлт

№	Гүйцэтгэх ажил, үйлчилгээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ /0-100 оноо/
1.	Аян зохион байгуулах талаар ажилчдад мэдээлэл хүргэсэн байх	Хурлын тэмдэглэл	<b>Тайлбар:</b> <ul style="list-style-type: none"><li>• Үйл ажиллагааны гүйцэтгэл бүрэн хангалттай бол 100 оноо</li><li>• Үйл ажиллагааны гүйцэтгэл дутагдалтай бол 50 оноо</li><li>• Үйл ажиллагааг огт хийгээгүй бол 0 оноо</li></ul>
2.	Аяныг зохион байгуулах талаар үйл ажиллагааг төлөвлөн баталгаажуулсан байх	Батлагдсан төлөвлөгөө	
3.	Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартад нийцсэн эсэхэд дотоодын хяналтын багаар үнэлгээ хийлгэсэн байх	Шалгуур, үнэлгээний дүн	
4.	Байгууллагын онцлог соёлд тулгуурлан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартад нийцүүлэн ажлын байрыг тохижуулах /дотоод тохижилт/	Тохижилтын ажилд зарцуулсан төсөв	
5.	Архи, тамхи, стресс бухимдал, өвчин эмгэггүй, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зохистой хооллолтыг дэмжсэн орчинг бий болгох /эрүүл мэндийг дэмжсэн орчин/	Хөтөлбөр, удирдамж, зөвлөмж гаргасан байна	
6.	Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хэвшүүлэх, мэдээллээр хангах, сургалт явуулах ажлыг зохион байгуулах /хувь хүн, хамт олны өөрсдийн оролцоог хангах/	Давтамж, хамрагдсан хүний тоо	
7.	Ажилчдыг вирусын илрүүлэг, оношилогоо, эмчилгээнд үе шаттай хамруулсан байх	Судалгаа, бусад баримт	

8.	Байгууллагын гадна ЭКО орчин бүрдүүлсэн байх /мод, бут, сөөг, цэцэг тарих, зүлэгжүүлэх гэх мэт/	Зарцуулсан төсөв	
9.	Аяны болзлын явцын хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх /вэб сайтаас харах/	Мэдээлсэн мэдээний тоо	

**Жич:** Аяны тайлан бичихдээ үйл ажиллагаа эхлэхээс өмнөх болон дараах байдлын зураг, бичлэг хавсаргах, ажлын гүйцэтгэлийг тоо хувь, мөнгөн дүнгээр товч тодорхой илэрхийлэх

Төвийн захирлын 2014 оны 04 дүгээр сарын 20 ны өдрийн 182 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

"ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН" АЯНЫ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэгч талууд	Хяналт тавих албан тушаалтан
1.	Аян зохион байгуулах тушаал, төлөвлөгөө, удирдамж боловсруулан батлуулж, бүтцийн нэгж болон ЗӨСТ-үүдэд хүргүүлэх	1Ү/15-20	ЧХУДАА	ЗТХНСА	ЗӨСҮТ-ийн Захирал
2.	Аян зохион байгуулах талаар байгууллагын ажилчдад ил тод нээлттэй мэдээлэл хүргэх	1Ү/21-25	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар
3.	Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартад нийцсэн эсэхэд дотоодын хяналтын багаар үнэлгээ хийлгэж, дүгнэл гарган цаашдын үйл ажиллагааг төлөвлөх	1Ү/20-Ү/1	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар
4.	Байгууллагын онцлог соёлд тулгуурлан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартад нийцүүлэн ажлын байрыг тохижуулах /дотоод тохижилт/	Аяны хугацаанд	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал Байгууллагын дарга нар
5.	Архи, тамхи, стресс бухимдал, өвчин эмгэггүй, идэвхитэй хөдөлгөөн, эрүүл зохистой хооллолтыг дэмжсэн орчинг бий болгох /жин хасах аян, еглөөний алхалт, цагаан хоолны өдөр гэх мэт /	Аяны хугацаанд	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар
6.	Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хэвшүүлэх, мэдээллээр хангах, сургалт явуулах ажлыг зохион байгуулах /хувь хүн, хамт олны өөрсдийн оролцоог хангах/	Аяны хугацаанд	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар

7.	Ажилчдыг вирусын илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд үе шаттай идэвхтэй хамруулах	илрүүлэг үзлэгийг 4, шинжилгээг 5, эмчилгээг 12 сард багтаах	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар
8.	Байгууллагын гадна хэсэгт ЭКО орчин бүрдүүлсэн байх /усан оргилуур, сүүдрэвч, мод, бут, сөөг, цэцэг тарих, зулэргүүлэх гэх мэт/	Аяны хугацаанд	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар
9.	Аяны болзлын явцын хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр нийтэд байнга мэдээлэх	Аяны хугацаанд	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	НЭМЭШСАЛба, Ажлын хэсэг
10.	Аяны нэгдсэн тайланг зураг, бичлэгээр баталгаажуулан хугацаанд нь ажлын хэсэгт ирүүлэх	XII/5	ЗӨСҮТ, ЗӨСТ-ийн удирдлагын баг	Алба, тасгийн дарга, эрхлэгч нар	Үндэсний төвийн захирал, Байгууллагын дарга нар



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

18131 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,  
Утас: 7028 2853, Факс: (976) 7028 2859,  
E-mail: nczd@nczd.gov.mn, http://www.nczd.gov.mn

2014. 04. 20. № 1/181

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

НИЙСЛЭЛ, АЙМГИЙН  
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ТӨВҮҮД, ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ЗООНОЗ-ХАЛДВАРТ ӨВЧНИЙ  
ТАНДАЛТ СЭРГИЙЛЭЛТИЙН ТӨВД

“Эрүүл мэнд -Ээлтэй орчин” аяныг  
зохион байгуулах тухай

“Эрүүл мэнд-Ээлтэй орчин” аяныг зохион байгуулах тухай Үндэсний төвийн захирлын тушаал, удирдамж, төлөвлөгөөг хүргүүлж байна.

Аяныг зохион байгуулахад доор дурдсан асуудалд анхаарч ажиллана уу. Үүнд:

1. Байгууллагадаа ажиллаж байгаа бүх ажилтныг “Эрүүл мэнд-Ээлтэй орчин” аянд хамруулах,
2. Аяны хүрээнд байгууллага орон нутаг, үндэсний хэмжээний мэдээний сан үүсэх тул хувь хүний мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахад орон нутгийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллах
3. Аяны илрүүлэг, оношилгоо, эмчилгээний шатны хугацаанд орон нутагт нөөц боломжийг дээд зэргээр ашиглан, бэлтгэл ажлыг ханган зохион байгуулах.

Дараах бичиг баримтуудыг хавсаргав.

1. Үндэсний төвийн захирлын 2017 оны <sup>А/104</sup> 124 тоот тушаал “Аян зохион байгуулах тухай”, 7 хуудас
2. Эрүүл мэндийн сайдын 02 тоот албан даалгавар “Эрүүл мэндийн ажилтны үзлэг, шинжилгээ, эмчилгээнд хамруулах тухай” 3 хуудас
3. Эрүүл мэндийн сайдын А/108 дугаар тушаал -

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

0000073